

**МОНГОЛ ХЭЛЭНДЭХ ХЯТАД ОРМОЛ ҮГИЙН ҮГИЙН
САН, УТГАЗҮЙН СУДАЛГАА**

Н.Балжинням¹

Т.Чахар²

Монголчууд эрт цагаас дэлхийн олон оронтой холбоо харилцаатай явж ирсэн учраас тэдгээр улсуудын хэлээс монгол хэлэнд олон үг орж улмаар монгол хэлний үгийн сан улам бүр баяжсаар ирсэн байна. Өнөөдөр монгол хэлэнд дэлхийн 30 орчим хэлний үг байна. Эдгээр үгс нь монгол хэлэнд шууд болон дам замаар орж идээшсэн байна. Ийнхүү монгол хэлэнд гадаад хэлний олон арван үг байнгын хэрэглээтэй байгааг монгол хэлний үгийн сан ядмаг, хэрэглээний үг дутсандаа бус харин ч монгол хэл хөгжингүй, хамгийн интернациональч хэл байж, энэ хэлээр ярилцагч монголчууд өөрсдөө оюунлиг, боловсролтой хүмүүс болохыг бэлхэнээ харуулж байна гэж зүй ёсоор үзэх ёстой.

Эдгээр ормол үгсийн дотор хятад хэлний үгс тодорхой байрыг эзлэж байна. Монгол хэлэнд орсон хятад хэлний үг олон тоотой байгаа, улмаар эдгээр үгс хэрэглээ ихтэй байгаа зэргийг тайлбарлахдаа хэд хэдэн зүйлийг анхааран үзэх болов уу. Юуны өмнө Монгол, Хятад хоёр орон хөрш зэргэлдээ оршиж, олон мянган километр газраар хил нийлж байгаа; манай хоёр орон урт удаан хугацаанд өргөн харилцаатай явж ирсэн; монгол оронд хятад хүмүүс нутагшин суурьшиж байсан, байгаа; монголчууд хятад нутаг газар аян жин тээж явж байсан; одоо хоёр орны хооронд өргөн харилцаатай болсон зэргээр үүнийг тайлбарлаж болох юм.

Гэхдээ Монгол, Хятад хоёр хэлний харилцан нөлөөллийн талаар, улмаар монгол хэлэнд орсон хятад үгийг үгийн сан, утгын талаас судлах ажил хангалттай биш, зөвхөн монгол хэл шинжлэлийн бичгүүдэд цөөн хэдэн үгийг ёс төдий давтан оруулж ирснийг тэмдэглэх нь зүйтэй. Энэ талын судалгаа өнөөдөр зүй ёсоор шаардагдаж байна. Хятад ормол үг монгол хэлний ярианы болон бичгийн хэлний аль алинд нь өргөн хэрэглээтэй байна. Харин монгол хэлэнд голдуу аман яриагаар дамжин орж идээшсэн байж болох юм. Эдгээр үгсийн монгол хэлэнд орж идээшсэн хугацааг тогтоох арга одоохондоо байхгүй юм. Ер нь ном, зохиолд ялангуяа дуу, шүлэгт байгаа үгсийг уг дуу шүлгийн зохиосон хугацаагаар баримжаалан авч үзэж болох юм. Эрт цагт монгол хэлэнд орсон үгийг одоо ялгаж танихын аргагүй болсон байна. Маш өргөн хэрэглээтэй болсон, хэлбэрийн хувьд монгол үгнээс ялгагдахын аргагүй болсон, өөрөөр хэлбэл авиан зүй, үгзүйн хувьд монгол үгтэй яг адилхан байгаа. Харин европын хэлнээс орсон үгийг танихад амархан байдаг, энэ нь харьцангуй ойрын хугацаанд орж ирсэн учраас ийм

¹ Доктор, профессор. МУИС-ийн МХСС-ийн сургууль

² МУИС-ийн МХСС-ийн сургууль

байна. Зарим хятад ормол үг монгол хэлний үгийн нэгэн адил хэрэглэгдэхгүй болж хуучин үг болох тохиолдол ч байна.

Оросын монголч эрдэмтэн, академич Б.Я.Владимирцов <<Монгол бичгийн хэл, халх аялгуу хоёрыг харьцуулсан хэлний зүй>> хэмээх бүтээлдээ хятад хэлнээс монгол хэлэнд орж идээшсэн зарим үгсийг тэмдэглэн тайлбарласан нь: пиу 票 piào - тэмдэгт, тасалбар, орос. билет, литер, англ. ticket, пүүс 铺子 pùzi - худалдааны гэр, орос. торговая фирма, магазин, англ. commercial firm, ноён 老爷 lǎoye - ноён, орос. нойон, князь, господин, англ. prince, king, хуушаан 和尚 héshàng - хөхийн шашны лам, орос. китайский (буддийский) монах, англ. Chinese Buddhist monk, хуй 会 huì - өртөөний хурал, жалгын хурал мэтийн бага сага хурал, орос. сборище, собрание, англ. medley; meeting, Дайду 大都 dàdū - Их нийслэл; Юань улсын үед Бээжинг ингэж нэрлэж байв. орос. Великая столица, англ. Capital City, сан 仓 cāng - хөмрөг, хөрөнгө, орос. казна; хранилище, англ. treasury; storehouse, даавуу 大布 dàbù - хөвөн, ноосон эд, орос. хлопчатобумажная ткань, англ. cotton fabric, мааюуз 马玉子 mǎyù zǐ - 1. эмээлийн дээр давхцаж хэрэглэх бяцхан дэвсгэр; 2. эмээл дээр бөгтрөн ганзгалах уут, орос. 1. подушечка на седле; 2. перемётная сума на седле, англ. 1. pin cushion on saddle; 2. saddle-bags, лянхуа 莲花 liánhuā - гүн улаан, гүехэн улаан буюу цагаан өнгөтэй, анхилам үнэртэй цэцэг; бадма ч гэнэ, орос. лотос, англ. lotus, боов 饽饽 bōbo - 1. гурилаар хийсэн идээн; 2. яриа. бэлэг эрхтэн, орос. 1. кондитерские изделия; 2. разг. половой орган, англ. 1. cake, pastry; 2. prick, cock, даа 大 dà~dài - 1. Даа, их; 2. дарга, ахлаач, орос. 1. великий, большой; 2. начальник, англ. 1. great; 2. head, chief, шаазан 植种 chá zhǒng - элс, шавар зэргийг боловсруулж хийсэн аяга, орос. фарфор; фаянс, англ. china porcelain; faience, тоор 桃儿 táozi - улаан шар өнгөтэй, үсэрхэг арьстай, сайхан амттай нэг зүйл жимс, мөнхүү жимс ургасан мод, орос. персик, англ. peach, жууз 轿子 jiàozi - тэрэг, хүн сууж явах дамнуурган сүйх, орос. паланкин, англ. sedan chair, litter; carriage, coach, жанжин 将军 jiāngjūn - цэргийн дээд зэргийн албан тушаалтан; сэнгүн, орос. полководец, англ. general, commander, янчаан 洋钱 yángqián - хятад улсын гүйлгээнд байсан Мексик мөнгөний нэр; мөнгөн төгрөг; хятад янчаан, орос янчаан, орос. китайский доллар, русский рубль, англ. silver dollar, dollar, silver coin, буу 炮 pào - 1. нэг зүйлийн мөрийтэй тоглоом; 2. галт зэвсэг, орос. играть в бу; оружие, англ. play bu; gun, хуанхэу 皇后 huánghòu - хааны эх; их хатан, орос. императрица, англ. empress, яам 衙门 yámen - аливаа нэг тухайлсан хэргийг хариуцсан улсын хэмжээний төвлөн захирах, удирдах том газар, орос. министерство, англ. ministry, маймай 买卖 mǎimài - худалдаа, арилжаа, орос. торговля, бизнес, англ. trade, business, тайган 太监 tàijiàn - хааны дотоод ордонд зарцлагдах агтлуулсан эрэгтэй, орос. евнух, англ. Eunuch, Бээжин 北京 běijīng - Бүгд Найрамдах Дундад Ард Улсын нийслэл /хойт нийслэл/, орос. Пекин /северная столица/, англ. Peking /north capital city/, тайж 太子 tàizi - хаадын угсаатан, орос. тайджи, дворянин, англ. taidji, nobleman, тайзуу 太祖 tàizǔ - эзэн хаан, орос. император, англ. emperor, тайван 太平 tàipíng - тавиу, амгалан, энх, орос. мир, спокойствие, англ. calmness, peace, хуар 花儿 huār - 1. цэцэг; 2. элдэв хээ угалз, орос. 1. цветы; 2. орнамент, англ. 1. flower; 2. ornament, шийгуа 西瓜 xīguā - тарвас, орос. арбуз, англ. watermelon, хуандий 皇帝 huángdì -

улсын/хятадын/ эзэн хаан, орос. *император*, англ. *emperor*, хуантайж 皇太子 huáng tàizi - жонон, агь, орос. *царевич, принц*, англ. *crown-prince, prince*, цонх 窗户 chuānghu - байшин, барилга зэрэгт гэрэл оруулахаар хийсэн гэгээвч, орос. *окно*, англ. *window*, дэн 店 diàn - буудал, буурчийн газар, орос. *постоялый двор*, англ. *inn, stopping-place*, ган 钢 gāng - маш хатуу төмөр, орос. *сталь*, англ. *steel*, янз 样子 yàng zi - 1. хэв маяг; 2. зан төрх, орос. 1. *вид, форма; тип стиль*. 2. *характер, поведение, нрав*, англ. *form, shape, kind*; 2. *character, conduct, disposition*, Шанду 上都 Shàngdū - дээд нийслэл; Хувилай хааны хаврын ордон байсан хот, орос. *Шанду-весенняя резиденция Хубилая*, англ. *Shan du - spring residence of Khubilai-khagan*, ван 王 wáng - 1. Манж Чин улсын үеийн хэтэрхий дөрвөн хэргэмийн нэгдүгээр зэрэг; 2. хааны нэгэн цол, орос. 1. *van (первая степень княжского достоинства)*; 2. *князь, король*, англ. 1. *prince of the first rank in Manchu times*; 2. *prince, king*, ваар 瓦 wǎ - 1. гонзгой сав; 2. байшингийн дээврийн материал, орос. 1. *ваза*; 2. *черепаца*, англ. 1. *vase, bowl*; 2. *tile*.

Монгол хүмүүн хятад ормол үгийг хэрхэн дуудаж, бичгийн хэлбэрийг тогтоож ирсэн талаар академич Б.Я.Владимирцов дээрх бүтээлдээ: “гадаад хэлнээс монгол хэлэнд орсон үг монгол хэлний авиан зүйгээр хэлбэржихдээ гадаад үгийн эхний эгшигээр баримжаалан эгшиг зохицох ёсыг баримтлана. Жишээлбэл, *чи чэ, лао йе, хуй, Дайдуу, хүүсан, жонон, чан гэ, ча жун тао эр, зяо зы, няо, нань зя, зянь зянь, ян цянь, пу зы, да бу, ма жу зы, линхуа, бо бо, да, пао, хоу, хуан хоу, я мынь, бао бэй, май май, тай зянь, дай мин, тай зу, тай пин* гэжээ.

Эндээс үзэхэд, эдгээр ормол үгс монгол хэлнээ идээшсэн улмаар монголчуудын өргөн хэрэглээний үгс болсон байсан нь мэдээж юм. Энэ хугацаагаар бодоход л бидний өнөөдрийн тухайлан авч үзээд байгаа үгс монгол хэлэнд эрт цагт орж ирсэн болох нь тодорхой байна. Монгол ардын аман зохиолын маш идэвхитэй төрлийн нэг болох монгол ардын дуунд хятад хэлний үг нэлээд хэмжээтэй байгаагаас үзэхэд хятад үг монголчуудын ярианы хэлэнд өргөн хэрэглэгдэж ирсэнийг харуулах нэг гэрч гэж үзэж болох юм.

Хэл шинжээчид аливаа нэг хэлний үгийн сангийн үндсэн бүтцийг судлахдаа тухайн улс үндэстэний аман зохиолд их анхаарал тавьж, энэ чиглэлийг голлон авч үздэг байна. Монгол ардын дуу нь тухайн үеийн нийгмийн ахуй байдлыг тусгасан гүнзгий утга агуулгатай, монголын ард түмний өвөрмөц зан заншил, амьдралын хэв шинжийг харуулсан байдаг. Энд хошин аястай, янаг амрагийн сэдэвтэй дуу зонхилсон байх ба дууны үйл явдал нь хөдөө хээрийн малын бэлчээрт голдуу болж байдгаарай онцлог юм. Монгол ардын дууны түүврээс бүртгэл хийж үзэхэд 60 орчим дуунд хятад ормол үг байна. Жишээлбэл, “Үмүү зандан ширээ”, “Юндэн гөгө”, “Янлин хуар”... зэрэг дуунд Хятад ормол үг монгол хэлний оноосон нэр болсон нь цөөнгүй байна.

Монголчуудын дунд Хуушаан 和尚 héshàng, Лоохууз 老胡子 lǎo hū zi, Манж 满族 mǎnzú, Мужсаан 木匠 mùjiang, Гуулин, Вандан 板凳 bǎndèng, Вандуй 豌豆 wǎndòu, Ембүү 元宝 yuánbǎo, Ган... 钢 gāng, Тайван 太平 tài píng, ...буу 炮 pào, Гүнжээ 公主 gōngzhǔ, Лянхуа 莲花 liánhuā, Хуар 花儿 huār, Цонх 窗户 chuānghu, Бээжин 北京 běijīng, Түнжин 同志 tóngzhì, Үжин 夫人 fūren (фужэнь) ... зэрэг нэртэй хүмүүс олон байна. Харь хэлний үг идээшсэн хэлэндээ хүний нэр болох хүртэл хэрэглэгдэнэ гэдэг нь мэдээж урт хугацааны замыг туулж байж л ингэнэ. Үүнээс гадна нийлмэл нэрийн хэсэг болж монгол хэлэнд идээшсэн үгэс ч олон байна. Жишээлбэл, Да хүрээ, Маймаан цол... гэх мэт.

Зарим хятад ормол үгийн утга монгол хэлэнд өргөжин шинэ утга хэрэглээг бий болгох явдал ч байна. Шөлөнд багсарсан гурил үрж буцалган иддэг хоол болох бантан 拌汤 bàntāng байна. Гэтэл энэ үг монгол хэлэнд хоолны нэр байхын зэрэгцээ утга нь шилжин ажил хэрэг бүтэлгүйтэх, будлиантайг холион бантан болох, бантан хийх, бантагнуулах, бантан хутгах...: байшин, барилга зэрэгт гэрэл оруулахаар хийсэн *гэгээвч* буюу цонх 窗户 chuānghu гэсэн үгийг анхны утгаар нь хэрэглэхийн зэрэгцээ сургууль соёлын газар хуваарьт хичээл цагтаа эс орохыг *цонх гарах, цонхлох, цонхтой байх...* зэргээр хэлнэ. Харин хятад үг монгол хэлэнд үндсэн утгаараа бус тухайн үгийн утга дагуу шинэ утга үүсгэн хэрэглэгдэх нь байна. Монгол хэлэнд орсон хятад үгс жинхэнэ утгаараа хэрэглэгдэхийн зэрэгцээ монгол хэлэнд утгыг нь шилжүүлэн хэрэглэх явдал бас байна. Толь бичгийн хэрэглэгдэхүүнийг шүүн үзвэл хятад хэлнээс монгол хэлэнд орсон одоо өргөн хэрэглээтэй байгаа 500 гаруй үг байгаа бололтой.

Эдгээр ормол үгийг зөвхөн тоолох, тоочих хэлбэрээр авч үзэх нь учир дутагдалтай болно. Ийм учраас тэдгээрийг зүйлчлэн ангилаж судлах явдал чухал байна. Үүнд: 1. Нийгмийн харилцааг зохицуулах төв байгууллага, түүний үйл ажиллагаатай холбоо бүхий нэр: *Баа* 罰 fá - торгууль зэмлэл, *банз* 板子 bǎn zi - эрүү шүүлтийн хэрэгсэл, *гэмин* 革命 géming - хувьсгалт цэрэг, *хуй* 会 huì - өртөөний хурал, жалгын хурал, цааз 册子 cèzi - дагаж мөрдөхөөр зааж тогтоосон дүрэм, журам, *ям* 衙门 yámen - аливаа нэг тухайлсан хэргийг хариуцсан улсын хэмжээний төвлөн захирах, удирдах том газар... гэх мэт. 2. Гэр бүл, ураг төрлийн холбоог заасан нэр: *Баавай* 爸爸 bàba - *нутг. аялг. аав, эцэг, гөөгөө* 哥哥 gēge - ах, *гүнж* 公主 gōngzhǔ - хааны төрсөн охин, *гэг* 格格 gége - Чин улсын үеийн ноёд, түшмэдийн охидын хүндэтгэл нэр, гүнжтэй адил, *шоожуу* 小姐 xiǎojiě - охин... гэх мэт. 3. Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах газар, түүний бүрэлдэхүүн хэсэг: *гуанз* 馆子 guǎnzi - хоол унд бэлтгэж худалдах газар, *дэн* 店 diàn - буудал, буурчийн газар, *лангуу* 拦柜 lánguì - худалдаа, үйлчилгээний газрын барааг хамгаалах тавцант хашлага... гэх мэт. 4. Зэр зэвсэг, түүний үйл ажиллагаатай холбоо бүхий нэр: *Ба* 靶 bǎ - 1. харвах, буудах шав; 2. мөрийтэй тэмцээний шагнал, *дайз* 带子 dàizi - сум агуулах уутат бүс, пуужин 炮舰 pàojiàn - буудсаны дараа агаарт тод өнгө гарган нисэх тусгай сум... гэх мэт. 5. Хүнсний ногоо, жимс жимсгэн, ургамалын нэр: *Байцаа* 白菜 báicài - цагаан ногоо, *вандуй* 豌豆 wāndòu - сэвэг зарам, хэмээх ургамал, *интоор* 櫻桃 yīngtáo - шүүслэг хар хүрэн жимс ургах мод, мөн энэхүү модонд ургах жимс, *лууван* 萝卜 luóbo - хоёр наст өвслөг ургамал; хүнсний ногооны нэг төрөл, хайтан 海棠 hǎitāng - ягаан, улаан цэцэгтэй хавар цэцэглэдэг нэгэн зүйл цэцэг, *чай* 茶 chá - зарим ургамлын хатаасан буюу боловсруулсныг усанд буцалгаж идээшүүлэн уух ундаан, *чилиийсэн* 七里香 qīlǐ xiāng - хүж өвс буюу долоон газрын үнэрт өвс. Яс хугарах, бэртэхэд хэрэглэнэ, *шуудуу* 疏导 shūdào - ус урсах хиймэл буюу ерийн суваг. 6. Гэр ахуйн эдлэл, хэрэглэлтэй холбоотой нэр: *Бандан* 板凳 bǎndèng - түшлэггүй нарийн урт сандал, *банз* 板子 bǎnzi - хавтгай мод, зүсмэл мод, *ганжин* 擀面杖 gǎnmiànzhàng - нухсан гурил нимгэлэх бөөрөнхий мод, гурилын мод, ганпанз 擀板子 gǎnbǎnzi - гурил элдэх хавтгай мод, *жинтүү* 枕头 zhěntou - хүний дэрлэх, түших хэрэгсэл, индүү 熨斗 yùndǒu - халааж юмыг тойруулан илүүрдэх зэвсэг; илүүр, *хоовон* 火盆 huǒpén - цогтой нүүрс хийж тавих сав, *цоож* 锁子 suǒzi - гэр, байшин, сав суулганы үүд, ам амсрыг бэхлэн торгож оньслох хэрэгсэл, *шүүгээ* 书柜 shūguì -

аливаа зүйлийг агуулахад зориулж хийсэн хаалга бүхүй босоо сав. 7. Хоол, идээний нэр: Бани 扁食 biǎnshí - татсан махыг гурилд боож буцалган идэх хоол, Бууз 包子 bāozi - боож бэлтгэсэн битүү хоол, хуушуур 火烧 huǒshāo - махан шанзтай шалбин, шийжүү 稀粥 xīzhōu - шингэн будаа... гэх мэтээр 30 гаруй зүйлд хуваан авч үзэж болно.

НОМ ЗҮЙ

Ковалевский Осип, Монгольско-Русско-Французский словарь, Казань, 1844 – 1849.

Lessing Ferdinand D., Mongolian – English dictionary, California, 1960.

Antoine Mostaert, Dictionnaire Ordos, New-York. London, 1968.

Балжинням Н., Монгол хэлний гадаад үгийн толь, УБ, 2005.

Вандуй Э., Дашдорж Ж., Орос-Монгол нэр томъёоны толь, УБ, 1970.

Bawden Charles R., Mongolian-English dictionary, London, 1992.

Кара Дьорд Монгол – Мажар толь, Будапешт, 1998.

Монгол Орос дэлгэрэнгүй их толь, I II III IV боть, Москва, 2001.

Монгол Хятад толь бичиг, Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 1991

Палей Я.Б., Юстов В.К., Краткий русско-китайский словарь, Москва, 1957.

Сүхбаатар О., Монгол хэлний харь үгийн толь, Улаанбаатар, 1990.

Цэвэл Я., Монгол хэлний товч тайлбар толь, Улаанбаатар, 1966.

Sechenchogtu, Monggul ьgen-ь ijagur-un toli, Цвер-monggul-un arad-un kevel-ьn khoriy-a, 1988.

Чэн Чан-Хао, Дубровский А.Г., Котов А.В., Русско-китайский словарь, Москва, 1953.

Shagja S., Monggol ьсыг-ьн дьrim-ьн toli bichig, Ulaganbagatur, 1927.

З.Баранова, А.В.Котов, Русско-китайский словарь, Москва, 1990

新蒙汉词典, 北京, 2002.

现代汉语词典, 北京, 2005.

俄汉大词典, 北京, 1993.

汉俄词典, 北京, 1989.

汉蒙词典, 北京, 2005.

РЕЗЮМЕ

В этой статье авторы освещают вопросы китайских заимствований в монгольском языке. По мнению авторов, китайские слова, вошедшие в монгольский язык в разное время истории Монголии, занимают своё место в лексике монгольского языка и активно употребляются и в письме, и в речи монголов. На их взгляды, это интерпретируется тем, что КНР и Монголия граничат друг с другом на расстоянии широких пространств и имеют добрососедские отношения с давних времён. А также, с одной стороны, на это имеют влияние постоянное жительство некоторых китайских эмигрантов на территории Монголии и, с другой стороны, наоборот монгольские караванщики занимались торговлей на китайской земле. Наконец, авторы пришли к выводу, что всё это обстоятельство повлияло на заимствования из китайского языка монгольским языком.